ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 08 өдөр Дугаар А/186 Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороог шинэчлэн
байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн дүрмийн 10.8.11 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 5.1 дэх хэсэг, "Иргэний нисэхийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид 2025-2027 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний 5.8 дахь заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн салбар нэгжийн ажилтан албан тушаалтан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий "Ёс зүйн дэд хороо"-г дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.Үүнд:

Гишүүд: Г.Содбаяр
(Захиргаа, санхүү удирдлагын газрын хүний нөөцийн менежер)

Д.Уртнасан
(Агаарын навигацийн үйлчилгээний газрын агаарын навигацийн менежмент, технологи үйл ажиллагаа хариуцсан менежер)

И.Амарсанаа
(Аэродром, гэрэл суултын албаны дарга)

Б.Золбоо
(Нисэхийн сургалтын төвийн захирал)

Ж.Зулцэцэг
(Захиргаа, хууль эрх зүйн хэлтсийн захиргааны ахлах мэргэжилтэн)

Э.Мөнхцэцэг
(Нисэх буудлуудын үйлчилгээний газрын нисэх буудлын нийтлэг үйлчилгээ, хөгжүүлэлт хариуцсан ахлах технологич мэргэжилтэн)

Б.Гэсэрбадам
(Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны тогтмол мэдээллийн мэргэжилтэн)

- 1726 04 0928

2.Гишүүдийн урамшууллыг хамтын гэрээнд заасны дагуу тооцож олгохыг Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс (Д.Булган)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны А/222 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү удирдлагын газрын дарга (Н.Золжаргал)-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЭНХЗОРИГ